

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/85/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗАР  
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: [saranchimegts@audit.gov.mn](mailto:saranchimegts@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: [auditulziit@gmail.mn](mailto:auditulziit@gmail.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/109

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант онд 48,941.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

019020191

## **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь тайлант онд Аймгийн 100 жилийн ойд зориулан хуримтлагдсан хур хогыг цэвэрлэх, усан оргилуурыг иж бүрэн ажиллагаанд оруулах ажлуудыг хийсэн байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,710,600.00</b>	<b>3,365,160.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>5,710,660.00</b>	<b>3,365,160.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>5,710,660.00</b>	<b>3,365,160.00</b>
35410	Бичиг хэргийн материал	455,160.00	333,660.00
35420	Аж ахуйн материал	3,711,500.00	905,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,241,800.00	1,250,000.00
35450	Барилгын засварын материал	302,200.00	876,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,702,616,639.28</b>	<b>3,472,596,708.77</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,702,616,639.28</b>	<b>3,472,596,708.77</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,328,301,639.28</b>	<b>2,098,281,708.77</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,305,068,972.15	3,305,068,972.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,104,917,626.07)	(1,358,870,004.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	658,791,996.00	658,791,996.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(589,605,967.75)	(606,822,622.32)
39205	Машин тоног төхөөрөмж	43,439,919.54	47,970,519.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,746,243.37)	(29,702,680.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,341,163.00	88,140,163.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,872,271.81)	(27,223,911.40)
39209	Зам гүүрний байгууламж	56,918,608.00	56,918,608.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(45,988,177.10)	(46,488,431.42)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	10,499,100.00	10,499,100.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	104,935,812.00	104,473,812.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(104,563,645.31)	(104,473,812.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,374,315,000.00</b>	<b>1,374,315,000.00</b>
39301	Программ хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,374,315,000.00	1,374,315,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,708,327,299.28</b>	<b>3,475,961,868.77</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>160,000.00</b>	
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>160,000.00</b>	
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>160,000.00</b>	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	160,000.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,708,167,299.28</b>	<b>3,475,961,868.77</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,708,167,299.28</b>	<b>3,475,961,868.77</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,378,790,604.74	2,378,790,604.74
51101	Өмч:-төрийн	2,378,790,604.74	2,378,790,604.74
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>675,586,179.51</b>	<b>443,380,749.00</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	675,586,179.51	675,586,179.51
51220	Тайлант үеийн үр дүн		(232,205,430.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	653,790,515.03	653,790,515.03
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,708,327,299.28</b>	<b>3,475,961,868.77</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,444,906,231.00</b>	<b>1,184,133,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>643,355,031.00</b>	<b>48,941,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>643,355,031.00</b>	<b>48,941,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	639,288,100.00	48,941,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	639,288,100.00	48,941,000.00
140020	Бусад орлого	4,066,931.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>801,551,200.00</b>	<b>1,135,192,300.00</b>
<b>1310</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>801,551,200.00</b>	<b>1,135,192,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	801,551,200.00	1,135,192,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,026,579,930.53</b>	<b>1,416,338,730.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,026,579,930.53</b>	<b>1,416,338,730.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,015,267,912.80</b>	<b>1,405,741,302.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>221,399,812.00</b>	
210101	Үндсэн цалин	221,399,812.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,662,068.00</b>	
210201	Тэтгэврийн даатгал	21,032,982.00	
210202	Тэтгэмжийн даатгал	2,213,997.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,771,198.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	331,263.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,312,628.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>61,065,295.00</b>	<b>259,324,021.98</b>
210301	Гэрэл, цахилгаан	61,065,295.00	252,667,743.50
210302	Түлш, халаалт		3,199,999.48
210303	Цэвэр, бохир ус		3,456,279.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>60,000,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун		60,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>464,078,129.27</b>	<b>797,529,749.98</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	464,078,129.27	797,529,749.98
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>240,062,608.53</b>	<b>288,887,530.51</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	240,062,608.53	288,887,530.51

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>27</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,312,017.73</b>	<b>10,597,428.04</b>
	Бусад урсгал шилжүүлэг		9,438,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		9,438,500.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,312,017.73	1,158,928.04
КТ(213403)	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,312,017.73	1,158,928.04
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>418,326,300.47</b>	<b>(232.205.430,51)</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>418,326,300.47</b>	<b>(232,205,430.51)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>805,618,131.00</b>	<b>1,135,192,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,066,931.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,066,931.00</b>	
140020	Бусад орлого	4,066,931.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>801,551,200.00</b>	<b>1,135,192,300.00</b>
<b>1310</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>801,551,200.00</b>	<b>1,135,192,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	801,551,200.00	1,135,192,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>805,618,131.00</b>	<b>1,125,265,700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>805,618,131.00</b>	<b>1,125,265,700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>794,306,131.27</b>	<b>1,114,668,271.96</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>113,391,300.00</b>	<b>259,400,471.98</b>
210301	Гэрэл, цахилгаан	113,391,300.00	252,667,743.50
210302	Түлш, халаалт		3,199,999.48
210303	Цэвэр, бохир ус		3,532,729.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>60,000,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун		60,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>680,914,813.27</b>	<b>795,267,799.98</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	680,914,813.27	795,267,799.98
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,312,017.73</b>	<b>10,597,428.04</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>9,438,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		9,438,500.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	<b>11,312,017.73</b>	<b>1,158,928.04</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,312,017.73	1,158,928.04
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		<b>9,926,600.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>9,926,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>9,926,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>9,926,600.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		9,926,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b>(9,926,600.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>653,790,515.03</b>	<b>257,259,879.04</b>	<b>3,289,840,998.81</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>				
Тайлант үеийн үр дүн			418,326,300.47	418,326,300.47
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>653,790,515.03</b>	<b>675,586,179.51</b>	<b>3,708,167,299.28</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн</b>	2,378,790,604.74	653,790,515.03	675,586,179.51	3,708,167,299.98
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			(232,205,430.51)	(232,205,430.51)
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,378,790,604.74</b>	<b>653,790,515.03</b>	<b>443,380,749.00</b>	<b>3,475,961,868.77</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,134,191,900.00</b>	<b>1,134,033,371.96</b>	<b>158,528.04</b>	<b>100.0%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,134,191,900.00</b>	<b>1,134,033,371.96</b>	<b>158,528.04</b>	<b>100.0%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,124,753,400.00</b>	<b>1,124,594,871.96</b>	<b>158,528.04</b>	<b>100.0%</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>259,559,000.00</b>	<b>259,400,471.98</b>	<b>158,528.02</b>	<b>99.9%</b>
Гэрэл, цахилгаан	253,889,800.00	252,667,743.50	1,222,056.50	99.5%
Түлш, халаалт	2,200,000.00	3,199,999.48	(999,999.48)	145.5%
Цэвэр, бохир ус	3,469,200.00	3,532,729.00	(63,529.00)	101.8%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>60,000,000.00</b>	<b>60,000,000.00</b>		<b>100.0%</b>
Бичиг хэрэг				
Тээвэр, шатахуун	60,000,000.00	60,000,000.00		<b>100.0%</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>805,194,400.00</b>	<b>805,194,399.98</b>	<b>0.02</b>	<b>100.0%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	805,194,400.00	805,194,399.98	0.02	<b>100.0%</b>
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,438,500.00</b>	<b>9,438,500.00</b>		<b>100.0%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,438,500.00</b>	<b>9,438,500.00</b>		<b>100.0%</b>
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,438,500.00	9,438,500.00		<b>100.0%</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,135,192,300.00</b>	<b>1,134,033,371.96</b>	<b>1,158,928.04</b>	<b>99.9%</b>
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,135,192,300.00	1,134,033,371.96	1,158,928.04	<b>99.9%</b>
Орон нутгийн төсөв	1,135,192,300.00	1,134,033,371.96	1,158,928.04	99.9%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>44</b>	<b>39</b>	<b>5</b>	<b>88.6%</b>
Удирдах ажилтан				
Гүйцэтгэх ажилтан	5	5		100.0%
Үйлчлэх ажилтан	39	34	5	87.2%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь Зуунмод сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх цэвэр аюулгүй орчныг бий болгох, цэмцгэр хотын төлөө ажлыг зохицуулан зохион байгуулахдаа хуваарилагдсан төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр дүнтэй ашиглаж, өрсөлдөх тэгш боломж олгох, хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Төв аймгийн Зуунмод сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зуунмод хотын хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан иргэдэд ая тухтай цэвэр үзэмжтэй, бохирдолгүй орчин бүрдүүлэх-тохижилт үйлчилгээний ажил хийж гүйцэтгэхэд оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт, хэрэгжүүлэх 43 арга хэмжээтэй баталснаас нийт 86,9%-тай дүгнэгдсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 232,365.5 мянган төгрөгөөр буюу 6,2 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	5,710.6	3,365.2	(2,345.4)
Үндсэн хөрөнгө	3,702,616.6	3,472,596.7	(230,019.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,708,327.2</b>	<b>3,475,961.9</b>	<b>(232,365.3)</b>
Өглөг	160.0		(160.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,708,167.3	3,475,961.9	(232,205.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,708,327.3</b>	<b>3,475,961.8</b>	<b>(232,365.5)</b>

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны үлдэгдэл 2,345.4 мянган төгрөгөөр буурсан нь Төв аймгийн 100-н жилээр бүтээн байгуулалтын ажил их хийгдэж урьд онд нөөц бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 4,530.6 мянган төгрөг, тавилга эд хогшил 54,799.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 462.0 мянган төгрөгөөр данс хооронд шилжүүлсэн хөрөнгийн дүнгээр буурсан байна. Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4,530.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 14,151.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авснаар үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,475,961.8 мянган төгрөг болж 232,205.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,174,471.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газарт нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 39,278.7 мянган төгрөгөөр зардлыг бууруулж 2023 оны урсгал зардлын төсвийг 1,135,192.3 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 1,135,192.30 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 1,134,033.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,135,192.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 1,158.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,134,033.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Сангийн яамнаас 2023 оны тохижилт, үйлчилгээний байгууллагуудын төсвийг батлахдаа бараа үйлчилгээний бусад зардлаас бүх зардлыг зарцуулахаар шийдвэрлэснээс шалтгаалан цалин хөлс, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд зарцуулах төсөв олгоогүй байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.	<b>71502- Хот байгуулалт тохижилт</b>				
1.1	82203-Нийтийн эзэмшлийн гудамж, талбай	245,500.0	245,500.0	0	100%
1.2	82204-Нийтийн эзэмшлийн гудамж, талбай	709,692.3	708,533.4	1,158.9	99.8%
1.3	82212-Хур хог хаягдал, орчны бохирдол	180,000.0	179,999.9	0.02	
	<b>Дүн</b>	<b>1,135,192.3</b>	<b>1,134,033.4</b>	<b>1,158.9</b>	<b>99.9%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 1.3-д харуулав.

#### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 479,759.7 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Гудамжны гэрэлтүүлгийн цахилгааны зардлыг 245,500.0 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, бараа үйлчилгээний бусад зардал, мэдээлэл технологийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 234,252.7 төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 169,300.00 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,026,579.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 15,398.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 11,549.0 мянган төгрөгөөр төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар тогтоосныг аудитын явцад дахин шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан, байр ашиглалттай холбоотой зардлыг 158.5 мянган төгрөгөөр хэмнэн ажилласан байна.

### **Судалгааны үр дүн, нөхцөл байдлын талаар бичих**

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар бүртгэлд байгаа үндсэн хөрөнгө болон цалин хөлс, урамшуулал, байр ашиглалт, эрүүл мэндийг дэмжих, цахим хэрэглээ, хэрэгжиж буй төсөл арга хэмжээтэй холбоотой 7 судалгааг ирүүлсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс 3 мэдээ хугацаа болоогүй, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар нь эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж хүргүүлснийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 32 тоот албан тоотуор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1		100%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>		<b>1</b>		<b>100%</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжөөр Шилэн дансны мэдээллийг бүрэн хийж хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Хот тохижуулах газар дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Залруулсан алдаа

Аудитаар нийт 563,965.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг залруулсан. Үүнд:

1.Тайлант оны эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан тайлангаас 535,235.1 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тооцоолсон цалингийн НДШ, ХХОАТ-ын тайлан 28,730.6 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх” зарчмыг хэрэгжүүлэн ажиллах гэж заасантай, санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 3,611.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тавилга эд хогшил дансны тайлант хугацааны элэгдлийг 3,611.6 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.35 дугаар зүйлд “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант хугацааны үндсэн хөрөнгийн дансны элэгдлийг үнэн зөв тооцон, санхүүгийн тайланд тусгах. Холбогдох заавар журмын дагуу тайлант хугацаанд элэгдлийг тооцоолж хэвших.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Эхний үлдэгдэл аудитлагдсан тайлангаас зөрүүтэй	1	535,235.1			1	535,235.1	1	535,235.1				
Цалингийн тооцоолол НДШ, ХХОАТ-ын тайлан	1	28,730.6			1	28,730.6	1	28,730.6				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>563,965.7</b>			<b>2</b>	<b>563,965.7</b>	<b>2</b>	<b>563,965.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Элэгдэл тооцоогүй	1	3,611.6					1	3,611.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,611.6</b>					<b>1</b>	<b>3,611.6</b>				